

МОНГОЛ УЛС БА БНХАУ-ЫН ӨМӨЗО -Ы ХАРИЛЦААНЫ ТОЙМООС

Ч.БАТЦЭЦЭГ*

Өвөр Монголын Өөртөө Засах Орон (ӨМӨЗО) бол БНХАУ-ын анхны үндэстний өөртөө засах орон юм. Хятадад ардын хувьсгал ялж БНХАУ байгуулагдахаас өмнө, манжийн ноёрхолын үеэс эхэлсэн монголчуудын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний үр дүнд 1947 онд Өвөр Монголын Өөртөө Засах Орон байгуулагдсан. ӨМӨЗО-д оршин суух монголчууд нь монгол угсааны олон аймгийн хойчис учраас өнөөгийн Монгол улс дахь монголчуудтай өнө эртнээс холбоотой явж иржээ.

XVII зууны үед монголчууд нь Өвөр Монгол, Халх, Баруун Монгол буюу Ойрад гэсэн гурван хэсэг байж улс төрийн талаар биеэ даасан байдалтай байв. Тэр үед монголын олон аймаг тус тусдаа биеэ даах сонирхолтой байсан учир Зүүн Монголын нэгэн хэсэг болох их говийн араар нутагладаг Ар Монгол буюу Ар Халх нь Түшээт хан, Сэцэн хан, Засагт хан гэсэн гурван ханы мэдэлд, нөгөө хэсэг Өмнөт Монгол буюу Өвөр Монгол нь Чахар, Харчин, Ордос, Түмэд, Хорчин, Урад зэрэг олон жижиг аймагт хуваагдсан, Ойрад буюу Баруун Монгол нь Дөрвөд, Торгууд, Цорос, Хошуд зэрэг аймгууд үе улиран угсаа залгамжилсан ноёд язгууртнуудын захиргаанд байсан юм. Манж нар тухайн үед нэлээд хүчирхэгжин, дотоодлоо зөрчил хагаралтай байсан Монголын нутаг руу довтлохоор бэлтгэж байв. Эхлээд Өвөр Монголыг эзлэн, дараа нь Ар Монголыг улмаар Баруун Монголыг арга хүч хослуулан хэрэглэж захиргаандаа оруулжээ. Өвөр Монголыг манж нар Монголын бусад хэсэг болон Хятадыг байлдан дагуулах түшиц газар болгон хүч хөрөнгийн нь дайчлан ашиглахын тул шинэ засаг захиргаа тогтоожээ. Засаг захиргааны өөрчлөлт хийж захирах болсноос улбаалан монголчууд нь өөрсдийгөө “Ар” Монгол, “Өвөр” Монгол нь “Тадаад”, “Дотоод” Монгол гэх болсон нь өнөө үед ч БНХАУ, Тайвань зэрэг зарим газарт Ар Монголыг “Тадаад Монгол”, Өвөр Монголыг “Дотоод Монгол” гэсэн нэр томъёог хэрэглэсээр байна.

Манжийн ноёрхолд орсон монголчууд бүр анхнаасаа эсэргүүцэн тэмцсээр ирсэн бөгөөд XX зууны эхнээс улам хүчтэй тэмцэж, 1911 онд Чин улс даяар өрнөсөн Цагаагчин гахай жилийн

* Ч.Батцэцэг- Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

хувьсгалтай давхцан монголчууд тусгаар тогтнолоо сэргээн тунхаглаж Олноо өргөгдсөн Монгол улсыг Ар Монголоор төвлөн байгуулахад Барга болон Дотоод Монголын олонхи чуулган, хошуу хөдлөж эхэллээ. Өвөр монголчууд Олноо өргөгдсөн Монгол улсын засгийн газарт Хятадад тогтсон Дундад Иргэн Улсын (ДИУ) цэргийн эрхтэний түрэмгийллээс чөлөөлж авахыг хүссэн айлтгал, өргөдөл олноор нь ирүүлсээр байлаа. Энэ үед Дотоод Монголын 6 чуулганы 49 хошууны 35 нь Монгол улсыг дэмжин түүнд нэгдэхээ ёсоор албан илэрхийлжээ.

Монгол улсын засгийн газар Ар, Өвөр Монголоос цэрэг дайчлан Өвөр Монголыг чөлөөлөх дайнд явуулахын зэрэгцээ цэргийн хэрэгцээт зарим зүйл болон Орос улсаас авсан буу зэвсгийг бас нийлүүлж эхэлсэн байна. Гэтэл Хаант Орос улс, Чин улсын суурин дээр тулгар тогтсон Дундад Иргэн Улс (ДИУ) хоёр хүч хавсран Монголын тусгаар тогтнолыг цуцалж, монголчуудын үндэсний эрх чөлөөний тэмцлийн төв болж байсан зөвхөн Ар Монголыг ДИУ-ын харьяанд автономит эрхтэй байлгах, түүнтэй нэгдээд байсан Хөлөнбуйрыг мөн улсын тусгай орон болгож бусад монголчуудыг Хятадын шууд ноёрхолд үлдээхээр болжээ.

Оросын 1917 оны хувьсгалаар далимдуулан 1919-20 онд автономит Гадаад Монгол, Баргын тусгай орныг Хятадын цэргийн эрхтэнүүд устгаж, ДИУ-ын шууд харьяанд оруулсан. Тэр үед Ар Монголд үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн дахин хүчтэй өрнөж, Зөвлөлт Орос улсыг түшиглэн Монгол Ардын Нам байгуулж, цөхрөлтгүй тэмцсээр 1921 онд төрийн тусгаар тогтнолоо сэргээн байгуулсан билээ. Харин Өвөр Монгол ДИУ-ын тусгай орнууд болон хуваагдаад улмаар мужуудын захиргаанд орсон боловч төрийн тусгаар тогтнолынхоо төлөө тэмцсээр Дотоод Монголын Ардын Хувьсгалт Нам байгуулсан юм.

Гэвч дотоод гадаад нөхцөл байдлын улмаас зорилгодоо хүрч чадалгүй задарч нэг хэсэг нь Хятадын Гоминьдан намтай нийлж, нөгөө хэсэг нь МАХН-ыг түшин нууц байдалд ажиллах болсон ажээ.

Японы түрэмгийлэгчид Хятадын Зүүн Хойт мужууд болон Өвөр Монголд түрэмгийлэн халдахал БНМАУ-ын ард түмэн эсэргүүцэж, хятад Өвөр Монголын ард түмний талд байгаагаа илэрхийлж, эд материалын болон сэтгэл санааны дэмжлэг үзүүлж байв.

Японы булаан эзлэгчдийн эсрэг БНМАУ, ЗХУ 1945 оны 8-р сарын 9, 10-нд дайн зарласан билээ. Монголын цэрэг дайчдыг дайнд үдэж мордуулахдаа Х.Чойбалсан "үндэс угсаа, хэл соёл, зан заншил, шашин мөргөл нэгтэй Өвөр Монголын ард түмнийг япон, хятадын дарлалаас ангижруулах нь Ардын хувьсгалт цэргийн байлдааны нэг зорилт мөн" ¹ гэж тэмдэглэжээ.

Өвөр Монголын ард түмэн харийн түрэмгийлэгчдээс

чөлөөлөгдсөндөө хязгааргүй баярлан, талархал илэрхийлж байсан бөгөөд тэр үед /1945.8.18/ Дотоод Монголын ардыг чөлөөлөх тунхаг бичиг баталж гаргажээ. Уг тунхаг бичгээс үзэхэд нутаг орноо чөлөөлж, БНМАУ-ын жишээгээр хөгжүүлж, яваандаа түүнтэй нэгдэх санааг илэрхийлсэн байдаг. Үүний зэрэгцээ өвөр монголчууд БНМАУ-ын засгийн газарт өдий төдий өргөдөл, захидал ирүүлж, БНМАУ-тай нэгдэх хүсэл эрмэлзлэлээ илэрхийлж, аймаг хошууд өөрийн төлөөлөгчдийг томилон явуулж байсан. Ер нь тусгаар тогтнох уу? Эсвэл БНМАУ-тай нэгдэх үү? Гэдэг асуудал тавигдаж, Өвөр Монголын нутаг даяар санал хураах хөдөлгөөн өрнөж байжээ. Гэвч энэ үед БНМАУ дэлхий дахинд хараахан хүлээн зөвшөөрөгдөөгүй, ЗХУ-ын дагуул маягтай байлаа. Дэлхийн дайн дуусч олон улсын байдал үндсээрээ өөрчлөгдөн, 1945 оны 2-р сард Ялт /Крым/-д болсон холбоотон гурван гүрний тэргүүн нарын Бага хурлаас БНМАУ-ыг одоогийн байгаа хилээр нь байлгах талаар гаргасан шийдвэр биелэгдэж эхэлсэн юм. Ийнхүү БНМАУ-тай нийлж нэгдэх гэсэн Өвөр Монголын ард түмний хөдөлгөөн Өвөр Монголын өөртөө засах хөдөлгөөнөөр хязгаарлагдсан билээ. Нөгөөтэйгүүр Улаанхүү тэргүүтэй коммунистууд Өвөр Монгол өөрөө засан тохинох бүрэн эрхээ эдлэхийн тул заавал орон нутгийн өөртөө засах байгууллыг дамжих ёстой гэж нотлон ятгаж байсан ажээ.

1947 оны 5 дугаар сард Өвөр Монгол нь Хятадын бүрэлдэхүүн дэх өөртөө засах эрх бүхий засаг захиргааны нэгж болсон юм. Тэгэхэд БНМАУ баяр хүргэж, цаашдын бүтээн байгуулалтанд их амжилт хүсэн ерөөж байв. Энэ үеэс БНМАУ, ӨМӨЗО-ы шинэ харилцаа эхэлсэн гэж хэлж болно. ӨМӨЗО нь БНМАУ-ын соёлын байгуулалтын туршлагыг судалж хэрэглэх, монгол шинэ үсгийг судлан дэлгэрүүлэх ажил зохиож байлаа. БНМАУ-ын ерөнхий боловсролын сургуулийн зарим сурах бичгийг монгол үсгээр хэвлэж олшруулаад сургуулиудад хэрэглэхийн сацуу БНМАУ-аас монгол хэлний мэргэжилтэн багш нарыг урьж ажиллуулж байв. 1950 оны 6 дугаар сард БНМАУ-аас БНХАУ-д суух анхны элчин сайд томилогдон очиход БНХАУ-ын Ардын Төв Засгийн Газрын Гадаад Явдлын Яамны сайд Жоу Энълай "... та нар Өвөр монголынхонтой өргөн харилцаа тогтоох хэрэгтэй. Нэг хэл, бичигтэй улс шүү дээ" гэж хэлж байжээ.

1957 онд Монгол улсын Ерөнхий Консулын Газрыг ӨМӨЗО-ы Хөх хотод нээн ажиллуулсан бөгөөд тухайн үеийн нөхцөл байдлаас шалтгаалан төдөлгүй 1959 онд хаасан байна. Хэдий тийм боловч БНМАУ-аас БНХАУ, ӨМӨЗО-д харилцан мэргэжилтэн солилцох (үүнд малын эмч, зоотехникч, соёл урлагийн ажилтан) оюутан сургах, урлаг соёлын арга хэмжээ эрчимтэй явуулж байсан талаар дурсамж, мэдээ сэлт элбэг байдаг. ӨМӨЗО оршин тогтносон эхний арван жилийн

туршид үндэсний соёлын байгуулалтын янз бүрийн салбарт амжилт олжээ.

1960 онд Улаанбаатар хотноо “БНМАУ, БНХАУ-ын найрамдал, харилцан туслах тухай Гэрээ”-нд гарын үсэг зурсан. Энэхүү гэрээ нь төрийн тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг харилцан хүндэтгэх, тэгш эрх, харилцан ашигтай байх зарчмыг тодорхойлсон түүхэн ач холбогдолтой гэрээ байв. Уг гэрээг 1994 онд шинэчлэн байгуулсан нь хоёр орны харилцааг улам бататган хөгжүүлэх үндсэн чиглэлүүдийг заасан тулгуур баримт бичиг болсон юм. Мөн 1962 оны 12 дугаар сард хилийн гэрээ байгуулж, түүний дагуу хилээ тогтоосон нь чухал үйл явдал болов. Харин 1966-1976 оны “Соёлын хувьсгалын” жилүүдэд харилцаа холбоо тасарч зогсонги байдалд орсон билээ.

БНХАУ 1978 онд хуралдсан ХКН-ын ТХ-ын III бүгд хурлаас дэвшүүлсэн чиг шугам шийдвэрийн дагуу эдийн засгийн шинэтгэлийг эрчимтэй хэрэгжүүлж, гадаадад нээлттэй байх бодлого баримтлах болов. Ингэснээр дэлхийн улс орнуудтай харилцаагаа сэргээн, хэвийн болгох үйл ажиллагаа явуулж эхэллээ. 80-аад оны дунд үеэс БНМАУ, БНХАУ-ын гадаад улс төрийн бодлого шинээр тодорхойлогдон, 1989 оноос хоёр орны улс төрийн харилцаа сэргэж, засгийн газар, нам, төрийн удирдагчид харилцан ажлын айлчлал хийж эхэлсэн юм. Анх 1989 онд ӨМӨЗО-ы Ардын Засгийн газрын дарга Бөхөө Монгол улсад ирж байсан бол өнгөрсөн арван жилийн хугацаанд ӨМӨЗО-ы Ардын Засгийн газрын төлөөлөгчид, Цэргийн тойргийн дарга нар, Намын Хорооны удирдлага, аймаг хотын дарга нар, ӨМӨЗО-ы Хятад-Монголын Найрамдлын Нийгэмлэгийн төлөөлөгчид ирсний сацуу БНХАУ-аас Монгол улсад төрийн албан ёсны айлчлал хийх төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд ӨМӨЗО-оос төлөөлөгч заавал багтдаг. Мөн Монгол улсаас ӨМӨЗО-д төдий хэмжээний хариу айлчлал хийж байгаа бөгөөд хамгийн сүүлийн жишээ дурьдахад 1998 онд Монгол улсын Ерөнхийлөгч Н.Багабанди БНХАУ-д албан ёсны айлчлал хийхдээ ӨМӨЗО-ы Хөх хот болон бусад аймагт зочилсон юм. Урьд нь ӨМӨЗО-той Хятадын төв Засгийн газраар дамжин харилцаж байсан бол одоо шууд харилцах болов.

1994 онд Хөх хотын Ерөнхий Консулын Газрыг сэргээн байгуулж, 1996 онд түүний салбарыг Эрээн хотод нээсэн бөгөөд харилцаа өргөжин хоёр орны хооронд зорчигчдын тоо нэмэгдсэн тул Улаанбаатар-Бээжин-Улаанбаатар-Хөх хотын хооронд суудлын галт тэрэг явуулдаг боллоо. Мөн түүнчлэн 1992 оноос Улаанбаатар-Хөх хотын хооронд тогтмол нислэг хийж байна. Замын-Үүд-Эрээн хотын хооронд зорчигч тээврийн унаа байнгын үйлчилгээтэй болжээ. Хөх хотод МИАТ компанийн төлөөлөгчийн газар тогтмол ажиллахын

зэрэгцээ хувийн томоохон пүүс компаниудын төлөөлөгчид ажиллаж, худалдаа хамтын ажиллагаагаа өргөжүүлж байна.

Монгол улс БНХАУ-тай хил залгаа 10 боомтоор (үүнээс 9 нь улирлын ажиллагаатай, 6 нь ӨМӨЗО-той хиллэдэг) гадаад худалдаа эрхлэх эрх бүхий байгууллагуудын хооронд бараа солилцоо, чөлөөт валютын зэрэг олон хэлбэрээр хилийн худалдааг явуулж байна. Түүний сацуу манай худалдааны 25 хувь нь БНХАУ-д ноогдож байгаагийн 75 хувь нь ӨМӨЗО-той хэрэгжүүлж буй хил худалдаа эзэлж байна. Хоёр орны хил орчмын аймаг муж, өөртөө засах орны хооронд шууд харилцаа тогтоож үр ашигтай хамтран ажиллаж байгаа билээ. Тухайлбал Улаанбаатар хот ӨМӨЗО-ы Хөх хот, Улаан хад хоттой, Эрдэнэт хот Бугат хоттой, Төв аймгийн Лүн сум Өвөр Монголын Дархан Муумянган хошуутай найрамдалт газрууд болжээ. Энэхүү хамтын ажиллагаа нь бүс нутгийг хөгжүүлэх, ард түмний итгэлцэл, найрамдлыг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой.

Хоёр талын хүмүүнлэгийн болон садан төрлийн харилцаа улам өргөжиж байгаа нь тус хоёр орны бас нэг онцлог юм. Сүүлийн жилүүдэд МХНН-ийн шугамаар төрөл бүрийн ажил зохиох, эрдэмтэд солилцох, оюутан, мэргэжил дээшлүүлэгчдийг сургах, урлаг спортын хэсэг, эмч, багш дасгалжуулагч гэрээгээр ажиллах, үзэсгэлэн-худалдаа гаргах, кино үзвэр зохиох, ном зохиол хэвлэх, хувь хүмүүс харилцан зорчих зэрэг олон салбар, чиглэлээр хамтран ажиллаж байна.

Манай улсын гадаад харилцаа өргөжин тэлж, олон улсын хамтын ажиллагаа ихээхэн хөгжиж байгаа өнөө үед БНХАУ-ын монгол туургатан оршин суух ӨМӨЗО-той харилцан хамтын ажиллагаагаа өрнүүлж байгаа талаар тоймлон өгүүлэхэд ийм байна.

Ашигласан материал:

1. Л.Жамсран "Монголын тусгаар тогтнолын сэргэлт" УБ., 1997
2. "Хятад дахь монголчууд" УБ., 1996
3. "БНХАУ-ын ӨМӨЗО" УБ., 1998
4. "Урд айл бидний харилцаа" Бээжин, 1998
5. Л.Бат-Очир "Чойбалсан" (намтрын нь балархайг тодруулахуй...) УБ., 1996
6. Тадаад харилцаа" товхимол УБ., 1999
7. "БНХАУ-ын ӨМӨЗО 1947-1987" ("Чжунго нэймэнгу зы чжи шуй") Бээжин, 1987